

2015 оны 03 сарын 28 өдөр

Дугаар: 002

Улаанбаатар хот

### Дотоод аудитын 2015 оны төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 6.2 дахь хэсэг, Сангийн Сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн 4.1.1 дэх заалт, дотоод аудитын хорооны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Дотоод аудитын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, Дотоод аудитын хороонд танилцуулж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Л.Батсайхан/-д даалгасугай.

САЙД, ДОТООД АУДИТЫН

ХОРООНЫ ДАРГА



Д.ЗОРИГТ

ЭРСДЭЛД СУУРИЛСАН ДОТООД АУДИТЫН 2015 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт			Хариуцах газар	
		Хугацаа	Чанар	Тоо	Хариуцах баг	
1	2	3	4	5	6	
1	Эрчим хүчний салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх	III улирал	Аудитын олон улсын стандарт, дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартууд, Сангийн сайдын 2010 оны 116 дугаар тушаалаар батлагдсан "Дотоод аудит явуулах заавар" Засгийн газрын дотоод аудит явуулах гарын авлага ашиглах	3	Д.Баяраа Ж.Саруул Д.Мөнхжаргал	
2	Эрчим хүчний салбарт концессийн гэрээгээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх	III улирал		3	Д.Баяраа Ж.Саруул Д.Мөнхжаргал	
3	Төрийн өмчит хувьцаат компани, төрийн өмчит үйлдвэрийн газруудын 2013-2014 оны үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх	I-IV улирал		3	Д.Баяраа Ж.Саруул Д.Мөнхжаргал	
4	Сайдын багцын 2015 оны төсвийн урсгал зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, худалдан авалт, татаас болон санхүүгийн бусад үйл ажиллагаа, дотоод хяналтын хэрэгжилтэд дотоод аудит хийх	IV улирал		1 багц	Д.Баяраа Ж.Саруул Д.Мөнхжаргал	